

**МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 19**ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5⁵.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Бүтээгдэхүүнээс дээж авах, түүнийг хадгалах, тээвэрлэхтэй холбогдсон журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Бүтээгдэхүүнээс дээж авах акт”-ын загварыг хоёрдугаар хавсралтаар, “Лабораторид дээж өгсөн тэмдэглэл”-ийн маягтыг гуравдугаар хавсралтаар, “Улсын байцаагчийн дүгнэлт гаргасан дээжийн мэдээ”-ний маягтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД**М.ЭНХБОЛД**

Улсын нэгдсэн бүртгэлийн 2011 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 3247 дугаарт бүртгэв.